



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд үр ашиггүй 14 нэрийн нийт 14,853,957.99 (арван дөрвөн сая найман зуун тавин гурван мянга есөн зуун тавин долоон төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Завхан аймгийн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Н.Батбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001520

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



**Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуй газрын үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Багана /гэрийн/	1995.01.01	ш	1	542.69	542.69
2	Дээвэр /гэрийн/	1997.11.12	ш	1	4,884.30	4,884.30
3	Тооно /гэрийн/	1999.09.01	ш	1	5,427.00	5,427.00
4	Унь /гэрийн/	1999.09.01	ш	1	8,683.20	8,683.20
5	Хаалга /гэрийн/	1999.07.01	ш	1	2,713.50	2,713.50
6	Хана /гэрийн/	1999.07.01	ш	5	1,085.40	5,427.00
7	Эсгий туурга /гэрийн/	1999.07.01	ш	2	2,713.50	5,427.00
8	Ширээ /шар/	1997.10.22	ш	13	64,219.50	834,853.50
9	Компьютер	2011.07.30	ш	1	639,999.80	639,999.80
10	Компьютер /делл/	2015.05.01	ш	1	1,120,000.00	1,120,000.00
11	Мотор /гагнуурын/	1998.10.23	ш	1	500,000.00	500,000.00
12	Принтер /ЦСҮТ/	2012.06.01	ш	1	176,000.00	176,000.00
13	Төмс ухагч	2014.12.31	ш	2	5,500,000.00	11,000,000.00
14	Санхүүгийн программ	2006.12.31	ш	1	550,000.00	550,000.00
	Нийт дүн			32		14,853,957.99 /арван дөрвөн сая найман зуун тавин гурван мянга есөн зуун тавин долоон төгрөг ерэн есөн мөнгө/